**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2025.04.08 № 6/1328 .

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯНМӨНХ ТАНАА

Даатгалын бүтээгдэхүүнийг
цахим хуудсанд байршуулсан тухай

“Тэнгэр даатгал” ХХК-аас 2025 оны 25/199 тоот албан бичгээр зөвшөөрлийн цахим системд ирүүлсэн “Бэлэн мөнгөний даатгал”-ын бүтээгдэхүүний мэдээлэл, баримт бичгийг Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн дагуу хүлээн авч танилцлаа.

Тус компанийн “Бэлэн мөнгөний даатгал”-ын бүтээгдэхүүн нь дээрх хууль, журмын шаардлагыг хангасан байх тул “Даатгалын багц дүрэм”-ийн 6.1.16-д “Даатгагч нь даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг шинээр болон шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан мэдээллийг Хороонд ирүүлэх ба тус мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд байршуулна” гэж заасны дагуу Хорооны цахим хуудсанд байршуулав.

ЦАХИМ БАТАЛГААЖЛАА ГАРЫН ҮСЭГ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | **Санхүүгийн зохицуулах хороо** |
| Газар хэлтэс: | **Даатгалын газар** |
| Албан тушаал: | **Дарга** |
| Овог нэр: | **Зоригт Батболд** |
| Зурсан огноо: | **2025.04.08 16:53** |

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4 дүгээр хавсралт

# Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

<table>
<tr><td>1</td><td>Мэдэгдэл огноо</td><td>Он</td><td>2025</td><td>Сар</td><td>03</td><td>Өдөр</td><td>10</td></tr>
<tr><td>2</td><td>Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр</td><td colspan="6">“Тэнгэр даатгал” ХХК</td></tr>
<tr><td>3</td><td>Даатгалын бүтээгдэхүүний нэр</td><td colspan="6">“Бэлэн мөнгөний даатгал”</td></tr>
<tr><td>4</td><td>Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр</td><td colspan="6">Хөрөнгийн даатгал</td></tr>
<tr><td rowspan="2">5</td><td rowspan="2">Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр</td><td colspan="3">Шийдвэрийн нэр</td><td colspan="2">Огноо</td><td>Дугаар</td></tr>
<tr><td colspan="3">Гүйцэтгэх захирлын тушаал</td><td colspan="2">2025.03.10</td><td>А/12</td></tr>
<tr><td>6</td><td>Цахимаар борлуулах эсэх</td><td colspan="6">☐ Тийм ■ Үгүй</td></tr>
<tr><td rowspan="2">7</td><td rowspan="2">Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:</td><td colspan="3">Овог</td><td colspan="3">Нэр</td></tr>
<tr><td colspan="3">Очирбат</td><td colspan="3">Батжаргал</td></tr>
<tr><td colspan="8">Мэдээллийн төрлийг сонгоно уу.</td></tr>
<tr><td>8</td><td colspan="7">■ Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах<br>☐ Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх<br>☐ Даатгалын бүтээгдэхүүнийг банк даатгалын зуучлагчаар дамжуулан борлуулах</td></tr>
<tr><td colspan="8">Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</td></tr>
<tr><td rowspan="4">9</td><td>Даатгалын зүйл</td><td colspan="6">Даатгуулагчийн зориулалтын сейфэнд хадгалагдаж буй бэлэн мөнгө /төгрөг, валют/, мөн энэхүү гэрээнд заасан маршрутаар тээвэрлэгдэж буй бэлэн мөнгө /төгрөг, валют/</td></tr>
<tr><td>Даатгалын үндсэн эрсдэл</td><td colspan="6">1. Галын эрсдэл, түймэр, тэсрэлт, дэлбэрэлт<br>2. Байгалийн эрсдэл, (хүчит салхи, газар хөдлөлт, аянга, шороон ба цасан шуурга, үерт авахуулах, аадар бороо, мөндөр)<br>3. Хулгай<br>4. Дээрэм, булаалт<br>5. Тээврийн эрсдэл (Бэлэн мөнгийг нэг байршлаас нөгөө байршил руу тээвэрлэх явцад гарах эрсдэл)</td></tr>
<tr><td>Даатгалын нэмэлт эрсдэл</td><td colspan="6">Байхгүй</td></tr>
<tr><td>Даатгалын хураамжийн хувь, хэмжээ</td><td colspan="6">1.0%-1.5%</td></tr>
<tr><td></td><td>Даатгалын шимгэлийн хувь хэмжээ</td><td colspan="6">10%-15% тохиролцоно</td></tr>
</table>